



Монгол Улсаас ХБНГУ-д  
суугаа Элчин сайдын яам



МОНГОЛ-ГЕРМАН  
DEUTSCHLAND-MONGOLEI

## МЭНДЧИЛГЭЭ

"Бидний оюун санаан дахь амьдралын өдөр тутмын тоосыг урлаг цэвэрлэдэг."  
ПАБЛО ПИКАССО

Олон улсын дүрслэх урлагийн НордАрт 2024 үзэсгэлэнд халуун мэндчилгээ дэвшүүлж, баяр хүргэх нь миний хувьд нэр төрийн хэрэг юм. Энэ удаагийн үзэсгэлэн үүсгэн байгуулагдсаны 25 жилийн ойн жилдээ болж буйгаараа онцлог бөгөөд хүндэтгэлтэй болж байна. Тодруулбал 1999 онд НордАрт нь алдарт Шлезвиг-Холштайн муж дахь төмрийн цутгах үйлдвэрийн түүхэн талбай – алдарт Карлсхүттэ-д анх нээгдсэн байдаг. Дэлхийн өнцөг булан бүрт орчин үеийн урлагийн бүтээлээ түүрвиж буй залуу уран бүтээлчдийг дэмждэг платформ гэдгээрээ НордАрт онцгой бөгөөд энэ төрлөөрөө дэлхийн тэргүүлэх үзэсгэлэнгүүдийн нэг аль хэдийн болжээ.

Манай улсын хувьд энэ жилийн үзэсгэлэн гурван онцлог ой давхардсан жилд тохиож байна. Монгол Улс, Холбооны Бүгд Найрамдах Герман Улстай дипломат харилцаа тогтоосны 50 жилийн ойг хоёр улс жилийн турш тэмдэглэн өнгөрүүлж байна. Түүнчлэн, Монгол Улс, НордАрт-тай амжилттай хамтран ажилласны 10 жилийн ой мөн тохиож байгаа нь энэхүү хамтын ажиллагааны ач холбогдлыг улам нэмэгдүүлж буй юм.

НордАрт 2024 үзэсгэлэнд Монгол улсаас шалгарсан 21 уран бүтээлч өөрсдийн өвөрмөц бүтээлээр оролцож байгаад баяртай байна. Энэ нь Элчин сайд миний бахархлыг төрүүлээд зогсохгүй, үзэсгэлэнг зохион байгуулагчид 25 жилийн ойн хүрээнд үзэсгэлэнгийн гол шагналыг хүртсэн бүх эздийг урьж оролцуулж буйд нэн баяртай байна. Тэдний нэг нь 2019 онд НордАрт-ын Гран При шагналыг хүртсэн Монголын нэрт уран бүтээлч, уран барималч Аюурзанын Очирболд юм. 2015 онд анх удаа энэхүү үзэсгэлэнд оролцоход тэрээр НордАрт-ын үзэгчдийн нэрэмжит шагналыг хүртэж, Монголын орчин үеийн урлагийг олон улсын анхаарлын төвд хүргэж, хүлээн зөвшөөрүүлж чадсан билээ.

Олон улсын тавцанд амжилттай яваа Монголын орчин үеийн урлагийн онцлог нь юуны түрүүнд нүүдэлчдийн олон мянган жилийн язгуур өв уламжлалыг орчин үеийн хэмнэл, уран сэтгэмжтэй гайхамшигтай хослуулан ур чадварын дээд зэрэглэлийн бүтээл болгож буйд оршдог.

Олон улсын үзэсгэлэнгийн гол зохион байгуулагч, ивээн тэтгэгч ноён Ханс-Юлиус Алманн, хатагтай Ёханна Алманн, ерөнхий куратор Волфганг Грамм, ахлах куратор Инга Ару, залуу куратор Тасо Грамм нарт чин сэтгэлийн талархал илэрхийлье. Монголын уран бүтээлчдийг НордАрт-д амжилттай оролцуулах, манай хоёр орны ард түмний найрамдал, нөхөрлөлийг бэхжүүлэх үйл хэрэгт түүштай хөдөлмөрлөж буй Монгол Улсын Соёлын Элч хатагтай Оюунжаргалын Оюунтуяад гүн талархаж байна. Мөн Улаанбаатар дахь "Соёл урлаг, хэвлэл мэдээллийн төслийн менежмент, зөвлөгөө" ТББ-д талархал илэрхийлье.

НордАрт 2024 үзэсгэлэнг өөрийн биеэр очиж үзэхдээ нэн таатай байх болно. Нийт уран бүтээлчид, зохион байгуулагчдад амжилт хүсье!

Монгол Улсаас ХБНГУ-д суугаа  
Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд  
Др. Бирваагийн Мандахбилэг

# NordArt 2024

©www.nordart.de



"Kunst wäscht den Staub des Alltags von der Seele."  
PABLO PICASSO

Es ist mir eine Ehre, der zeitgenössischen Internationalen Kunstaussstellung NordArt 2024 meine herzlichen Grüße und Glückwünsche zu übermitteln. Die diesjährige Ausstellung genießt eine besondere Bedeutung und Achtung, da sie ihr 25. Gründungsjahr bzw. Geburtstag feiert. Vor einem Vierteljahrhundert, genau 1999, wurde die NordArt auf dem historischen Gelände der Eisengießerei in Schleswig-Holstein – in der berühmten Carlshütte – ins Leben gerufen, und sie gehört schon jetzt zur Weltelite in ihrer Eigenschaft als Förderpodium für junge kreative Kunstschöpfer aus der ganzen Welt.

Aus Sicht meines Landes findet die Ausstellung in einem Jahr der dreifachen Jubiläen statt. Die Mongolei und die Bundesrepublik Deutschland feiern gemeinsam den 50. Jahrestag der Aufnahme diplomatischer Beziehungen gebührend das ganze Jahr hindurch. Hinzu kommt, dass die Mongolei und die NordArt ihre zehnjährige erfolgreiche Zusammenarbeit begehen, was dieser Kooperation noch mehr Bedeutung verleiht.

Zur NordArt 2024 kommen 21 ausgewählte Künstlerinnen und Künstler aus der Mongolei mit ihren einzigartigen Schöpfungen. Das macht mich als Botschafter sehr stolz, und ich freue mich, dass die Organisatoren der Ausstellung alle Preisträger\*Innen aus den 25 Jahren zu ihrem Jubiläum eingeladen haben. Unter ihnen ist der bekannte mongolische Künstler und Bildhauer Ochirbold Ayurzana, der 2019 den NordArt-Preis gewann. Schon bei der ersten Teilnahme der mongolischen Künstler\*Innen 2015 konnte er den Publikumspreis der NordArt gewinnen und somit auf Anhieb internationale Anerkennung und Aufmerksamkeit für die Gegenwarts-kunst aus der Mongolei erwerben.

Die Besonderheit der erfolgreichen modernen mongolischen Kunst auf internationaler Bühne liegt vor allem darin, die Jahrtausende alten nomadischen Wurzeln und Traditionen und die tempo- und phantasiereiche Moderne in der künstlerischen Symbiose mit höchstem Können zu kombinieren.

Mein recht herzlicher Dank gilt vor allem den beiden Mäzenen und Gastgebern Hans-Julius Ahlmann und Johanna Ahlmann, dem Chefkurator Wolfgang Gramm, der Seniorkuratorin Inga Aru und dem Juniorkurator Taso Gramm. Mein besonderer Dank gilt an dieser Stelle auch Frau Oyuntuya Oyunjargal, die Kulturgesandte der Mongolei, die sich für die erfolgreiche Teilnahme mongolischer Künstler\*Innen an der NordArt und für die bilaterale Völkerverfreundschaft ehrgeizig einsetzt. Der Arts & Media Project Management & Consulting NGO aus Ulaanbaatar danke ich auch.

Ich freue mich sehr, die jubelnde NordArt 2024 persönlich zu besuchen und besichtigen. Ich wünsche allen teilnehmenden Künstlern und Organisatoren viel Erfolg und Freude!

S.E. Dr. MANDAKHBILEG Birvaa  
Außerordentlicher und bevollmächtigter Botschafter  
der Mongolei in der Bundesrepublik Deutschland

"Art washes away from the soul the dust of everyday life."  
PABLO PICASSO

It is an honor for me to send my warmest greetings and congratulations to the International Contemporary Art Exhibition NordArt 2024. This year's exhibition enjoys special significance and respect as it celebrates its 25th anniversary. A quarter of a century ago, in 1999, to be precise, NordArt was launched on the historic site of the iron foundry in Schleswig-Holstein – in the famous Carlshütte – and it has already become one of the world's elites in its capacity as a promotional platform for young creative artists from all over the world.

From my country's perspective, the exhibition is taking place in a year of triple anniversaries. Throughout the year, Mongolia and the Federal Republic of Germany will continue to celebrate the 50th anniversary of the establishment of diplomatic relations. In addition, Mongolia and NordArt are marking exactly the 10th anniversary of their successful partnership, granting this collaboration project an even greater significance.

As an ambassador, it fills me with pride to announce that NordArt 2024 will feature 21 selected artists from Mongolia, showcasing their unique creations. I am delighted that the exhibition organisers have extended invitations to all the award winners from the past 25 years for this special anniversary edition. Among them is the well-known Mongolian artist and sculptor, Ochirbold Ayurzana, who was honored with the NordArt Prize in 2019. Ayurzana's journey with NordArt began in 2015 when Mongolian artists first participated, and his remarkable achievement of winning the NordArt Public Award immediately garnered international recognition and attention for contemporary art from Mongolia.

The hallmark of successful modern Mongolian art on the international stage lies, above all, in the fusion of thousands of years of nomadic roots and traditions with a rich tapestry of modernity, imbued with pace and imagination, all in artistic symbiosis with the highest level of skill.

My heartfelt thanks go above all to the hosts and patrons Hans-Julius Ahlmann and Johanna Ahlmann, Principal Curator Wolfgang Gramm, Senior Curator Inga Aru and Junior Curator Taso Gramm. My special thanks go to Mrs Oyuntuya Oyunjargal, the Cultural Envoy of Mongolia, who is ambitiously committed to the successful participation of Mongolian artists in NordArt, and for the mutual friendship between our people. I would also like to thank the Arts & Media Project Management & Consulting NGO from Ulaanbaatar.

I am very much looking forward to visiting and viewing the jubilant NordArt 2024 in person. And I extend my sincerest wishes to all the participating artists and organizers for their success and joy.

H.E. Dr. MANDAKHBILEG Birvaa  
Ambassador Extraordinary and Plenipotentiary  
of Mongolia in the Federal Republic of Germany